

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРД ХҮҮГЦЭН

МАК ЦЕМЕНТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.БАТТУЛГА

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ МАК
ЦЕМЕНТ ХХК-ИЙН ЗАМЫН ХӨХ ТОЛГОЙН ДАЙРГАНЫ ОРД ТӨСЛИЙН 2026
ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5830974

ТАНИЛЦСАН

УУРХАЙН ДАРГА

Т. ЦЭРЭНДАШ ✓

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН ТОГТВОРТОЙ

ХӨГЖЛИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН 

Э.БАТСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

ЭКОЛОГИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ДАВАА

2026 он

ГАРЧИГ

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ.....	4
УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ, АЖИЛЛАХ ГОРИМ	6
1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	
9	
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	11
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	13
4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	18
9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО	22

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1.АЖИЛЛАХ ГОРИМ	6
ХҮСНЭГТ 2. ИЛ УУРХАЙН ҮНДСЭН ХЭМЖЭЭСҮҮД	6
ХҮСНЭГТ 3. СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
ХҮСНЭГТ 4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
ХҮСНЭГТ 5. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
ХҮСНЭГТ 6. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
ХҮСНЭГТ 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
ХҮСНЭГТ 8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	18
ХҮСНЭГТ 9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ДАРААХ АЖЛУУДЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХЭЭР ТӨЛӨВЛӨВ.	20
ХҮСНЭГТ 10. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ.....	21
ХҮСНЭГТ 11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ УРЬДЧИЛСАН ЗАРДАЛ	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. БУТЛАХ, ШИГШИХ ТЕХНОЛОГИЙН СХЕМ.....	7
ЗУРАГ 2. ХАЦАРТ БУТЛУУРЫН СОНГОЛ: JS-3 МАРКИЙН БУТЛУУР	8

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн танилцуулга: “Монголын Алт” (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг юм. Манай компани уул уурхай, барилгын материалын үйлдвэр, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байна.

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн Хөх цавын цемент шохойн үйлдвэрийн төсөл болон дагалдах уурхайнуудын үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэхээр 2014 оны 04-р сарын 16-нд “МАК Цемент” ХХК байгуулагдсан.

Компанийн байгаль орчны бодлого:

Бидний эрхэм зорилго: Компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд байгаль орчинд үүсч болох аливаа сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах талаар анхааран ажиллах нь компанийн нийт ажиллагсадын нэн тэргүүний зорилт болно.

Бидний дээдлэх үнэт зүйлс: Компани ба түүний салбар нэгжүүд нь үйлдвэр, уурхайн төслийг боловсруулах шатнаас үйл ажиллагааныхаа бүх хүрээнд байгаль орчны асуудлыг байнга анхаарч Монгол улс болон олон улсын хэмжээнд мөрдөж буй уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны холбогдолтой хууль, дүрэм, журам, гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөнө. Эх орон, төрсөн нутаг, усаа хайрлан хамгаалах нь компанийн бүх ажилчид албан хаагчдын үнэт зүйл болох учиртай.

Баримтлах бодлого: Манай компани нь дараах зорилтуудыг дэвшүүлж ажилладаг. Үүнд:

- Байгалийн нөөц баялгийг урт удаан хугацаанд тогтвортой, үр ашигтай зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар баримталж ирсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлж, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг тогтмол гүйцэтгэх;
- Улсын болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгаль орчныг хамгаалах чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- Олон улсын байгаль орчны байгууллагууд болон байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий туршлагатай компаниудтай хамтран ажиллаж, улмаар олон улсын байгаль орчны стандартуудыг өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
- Нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөц баялгийг ариг гамтай, хаягдалгүй технологи болон дахин боловсруулах аргаар ашиглах;
- Байгалийн нөөцийн ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа шинжилгээг явуулж орчин үеийн үр ашигтай техник, технологийг үйлдвэрлэлдээ тууштай нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэдийн соёл, өв уламжлалыг хүндэтгэн хамгаалах, тэдний биет өв, ёс заншлын талаархи мэдээлэл, тэдгээрийн ач холбогдлыг компанийн ажилчдад тогтмол таниулах;

- Өөрийн компанийн байгаль орчны талаар баримтлах бодлого зарчмыг хамтран ажиллаж буй түнш, гэрээт гүйцэтгэгч нарт зааж таниулах, тавих шаардлагыг өндөржүүлэх замаар байгаль орчны чиглэлээр тэдний хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх;

Замын хөх толгойн тусгай зөвшөөрөл бүхий талбай дахь дайрганы болон хөнгөн цагаант материалын чулуулгийн орд нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт, төмөр замын 25-р зөрлөгөөс зүүн урагш 1,5-2,5 км, Улаанбаатар хотоос 325 км зайд оршино.



Зураг 1. Төслийн байршлын зураг

Газар зүйн байршлын хувьд район нь говийн бүсэд хамаарах бөгөөд, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Жилийн хамгийн хүйтэн хугацаа нь 1-2-р сарууд бөгөөд эдгээр саруудад агаарын температур нь $-20-25^{\circ}\text{C}$ хүрэх ба зарим тохиолдолд хааяа -35°C , хамгийн дулаан нь 7-р сард $+25-+30^{\circ}\text{C}$ заримдаа $+35^{\circ}\text{C}$ хүрнэ. Энэ районд салхи ихэнхдээ баруун, баруун хойноос чиглэлтэй салхилах бөгөөд салхины хурд нь гол төлөв 5-10 м/сек орчим байна. Хаврын саруудад хүчтэй шороон шуурга их болдог. Тус дүүрэг нь төмөр зам болон дэд бүтцийн хувьд харьцангуй сайн хөгжсөн, уул уурхайн үйлдвэрлэл ялангуяа нүүрсний болон барилгын материалын чиглэлээр уурхай, үйлдвэрүүд эрчимтэй хөгжиж байгаа бүс нутаг. Нутгийн ард түмэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх ба сүүлийн үед орон нутгийн залуус уул уурхайн салбарт тодорхой хэмжээний ажил эрхэлж байна.

УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ **Агаар мандалд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл:**

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлох зорилгоор хээрийн хэмжилт, бохирдлын тархалт зураглалын программ хангамж, бохирдлын тооллого хийх аргачлалын дагуу тооцоолол, судалгааг хийж гүйцэтгэсэн. Төслийн зүгээс дайрга олборлох, тээвэрлэх, бутлах, шигших үйл ажиллагааны процессууд болон машин техникийн хөдөлгөөнөөс агаарт тоос дэгдэх, агаарт хорт хийн бохирдол үүсэж болзошгүй байна.

Газрын хөрсөнд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Төсөл хэрэгжих хугацаанд уурхайлалтад нийт 3.8 га талбай,
- 11.4 мян.м3 шимт хөрс үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх,
- Олборлолтын хугацаанд газрын хэвлийд хамгийн 26 м гүн, 1011.1 мян.м3 хоосон орон зай үүсэх,
- Хөрсний овоолго нь газрын гадаргад 10 м өндөртэй, 1.5 га талбайг эзэлсэн овоолго бий болж газрын гадарга, төрхийг өөрчлөх,
- Уурхайн техникийн үйл ажиллагаа нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг, ордыг ашиглах үед газрын хөрс, түүний геологийн тогтоц, хэвлийд өөрчлөлт гарах,
- Олборлолтын талбайгаас эргэн тойрон 100 м зайд хөрс, ургамал талхлагдах, халцрах зэргээр сөрөг нөлөөлөл бий болох,
- Ордын ашиглалтын талбай орчмын ургамал талхлагдах, хөрс хуулалтын улмаас уурхайн талбайн ургамлан нөмрөг бүрэн устах, хөрсний овоолгод дарагдах,

Ургамлан нөмрөгт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:

Судалгаа явуулсан талбайд ургамал нөмрөг одоогийн байдлаар бага зэрэг нөлөөлөлд өртсөн байдалтай байна. Иймээс энэхүү нөлөөлөлд өртсөн болон цаашид нэмэгдэн өртөх талбайн хэмжээтэй тэнцэхүйц өөр газарт нөхөн сэргээлтийн арга хэмжээг явуулах шаардлагатай. Иймд нөлөөлөлд өртөх талбайн хэмжээтэй тэнцэхүйц өөр талбайд ба сум, багийн нөхөн сэргээлт, мод, зүлэгжүүлэлт хийх шаардлагатай байгаа газарт нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэх. Тухайн ургамалжлын нөлөөллийн түвшин, газрын гадаргуу зэрэг бусад онцлогоос шалтгаалан таримал ургамлыг сонгон тарьж нөхөн сэргээлтийн ажлыг мэргэжлийн байгууллагаар өндөр түвшинд гүйцэтгүүлэх шаардлагатай. Энэхүү нөхөн сэргээлтийн ажилдаа сум, багийн ард иргэд ялангуяа малчдыг татан оролцуулж тариалалт хийж, ард иргэдийг ногоон байгууламжын ажлын арга зүйд давхар сургах нь шаардлагатай.

Усан орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл:

Газрын доорх усны чанар: Авто засварын газар болон авто машинаас шатахуун болон шатах тослох материал асгаран хөрсөн бүрхэвчээр дамжин гадаргын болон газрын доорх усанд нэвчих бохирдол үүсэх; хур бороо, үерийн усаар гадаргын угаагдал үүсэн улмаар гүний усыг бохирдуулах; уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хатуу хог хаягдал зэргийн үлдэгдэл угаагдан хөрс, газрын хэвлийг бохирдуулах улмаар гүний усыг бохирдуулах

Газрын доорх усны нөөц: Уурхайн ажилчдын унд ахуйн усны хэрэглээ; уурхайн тээвэрлэлтийн замын зам талбайн усалгаа зэрэг болно.

Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл:

“Замын Хөх Толгой”-н дайрганы үйлдвэрийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл сул боловч төслийн бусад бүрэлдэхүүн хэсгүүд болох ажилчдын сууц, автозам, хогийн цэг, машин механизмаас гарч буй дуу чимээнээс болж томоохон хөхтөн амьтад төслийн талбайгаас дайжих, жижиг мэрэгч, мөлхөгчид тээврийн хэрэгсэлд дайруулах тохиолдол гарна. Хөрсний эвдрэл, доройтол, орчны тоосжилт, үйлдвэрлэлийн улмаас ургамал идэшт амьтдын тоо толгой буурах нөлөөлөл гарна.

УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ, АЖИЛЛАХ ГОРИМ

“Замын хөх толгой”-н дайрганы ордыг ил аргаар ашиглах төслөөр 24.9 мян.м³ хөрс хуулж 32.3 мян.м³ дайрга олборлож хөрс хуулалтын дундаж коэффициент 0.26 м³/тн байхаар тооцож уулын ажлыг гүйцэтгэнэ.

Уурхайн дотоод тээвэр /хөрс болон дайрга/

“Замын хөх толгой” нь 2026 онд хөрс тээвэрлэлтийн ажилд Nowo-371 маркийн 54тн даацтай автосамосвалаар гүйцэтгэнэ. Хөрсийг гадаад овоолгод байршуулах бөгөөд олборлосон дайргыг бутлуурын талбайд буулгана. Хөрс болон дайрга тээвэрлэлтийн дундаж зайг 0.5км-1 км зайд тээвэрлэхээр тооцов.

Ил уурхайн ажиллах горим

2026 онд “Замын хөх толгой”-н дайрганы уурхайн ажиллах горимыг МАК Цемент ХХК-ын уурхайнуудад мөрдөгдөж буй дараах байдлаар тасралтгүй ажиллагаатайгаар ажиллана.

Уурхайн ажлын горимын үзүүлэлт

Хүснэгт 1. Ажиллах горим

Д.д	Үзүүлэлт	Хугацаа
1	Ээлжийн тоо	2
2	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	12
3	Ээлжин дэх амралт	1
4	Ээлжийн бэлтгэл, төгсгөл	1
5	Бүтээлтэй ажиллах цаг	10
6	Ээлжийн цаг ашиглалт	0.7
7	Календарийн хоног	365
13	Жилд ажиллах хоног	260

Уурхайн ашиглалтын систем

“Замын хөх толгой”-н ордыг ашиглах уурхай нь авто тээвэртэй ашиглалтын системийг хэрэглэнэ. Дайрганы ордын олборлолтын нөхцөл, хэмжээ, жилд хийгдэх нийт уулын ажлын эзлэхүүн зэргээс хамаарч хөрс хуулалт, шавар, элс олборлолтын ажлыг экскавациалт – автосамосвал – дотоод овоолго гэсэн ил уурхайн технологиор гүйцэтгэнэ.

2026 онд нийт 24.9 мян.м³ хөрс хуулж 32.3 мян.м³ дайрга олборлож хөрс хуулалтын дундаж коэффициент 0.26м³/тн байхаар тооцож уулын ажлыг гүйцэтгэнэ.


Хүснэгт 2. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд

№	Ил уурхайн үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Ил уурхайн гүн /хамгийн их утга/	м	1135
2	Ил уурхайн хажуугийн өнцөг	град	65
3	Хөрсний доголын өндөр	м	2
4	Ашиглалтын доголын өндөр	м	5
5	Авто замын өргөн	м	15
6	Налуу замын өнцөг	промилль	80
7	Ажлын талбайн өргөн	м	30

Чулуулгийг бутлах шигших процесс: Уурхай нь жилд 30.0 мян.м³ барилгын чулуу олборлох ба цагт 60 тн дайрга боловсруулах шаардлагатай болно. Барилгын чулууг хацарт бутлуураар бутлан, шигшүүрээр шигшин, +20 мм-ээс дээш бүтээгдэхүүн дахин бутлагдан эргэлтийн ачааллаар шигшүүрт өгөгдөнө. Туузан дамжуургаар 0-5 мм, 5-10 мм, 10-20 мм-ийн ширхэглэлийн эцсийн бүтээгдэхүүн дайрга гарна.

Баяжуулах цех нь жилд 39.6 мян.м³ дайрга боловсруулна.

Зураг 1. Бутлах, шигших технологийн схем




Цагийн бүтээмжийн тооцоо: Бутлан ангилах цех нь жилд 39.6 мян.м³ дайрга буюу барилгын чулуу боловсруулах бөгөөд өдөрт 12 цагаар 1 ээлжээр ажиллах юм. Бутлан ангилах цехийн цагийн бүтээмжийг дараах хүснэгт 5-9-д үзүүлэв.

Хүснэгт 3. Бутлан ангилах цехийн цагийн хүчин чадал


№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Qж	Барилгын чулуу бутлах цехийн жилийн хүчин чадал	мян.м ³
2	Qж	Барилгын чулуу бутлах цехийн жилийн хүчин чадал	мян.тн
3	N	Жилд ажиллах хоногийн тоо	хоног
4	n	Нэг ээлжинд ажиллах цаг	цаг
5	m	Хоногт ажиллах ээлжийн тоо	ш
6	KЗ	Тоног төхөөрөмжийн цаг ашиглалтын коэффициент	
7	Qц	Цагийн хүчин чадал	тн

Зураг 2. Хацарт бутлуурын сонгол: JS-3 маркийн бутлуур




Хүснэгт 4. Хацарт бутлуурын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Тоо хэмжээ
1	Бутлах төхөөрөмж, төрөл	PE-1100x850
2	Тэжээлийн орох амны хэмжээс, мм	1200x4000
3	Тэжээлийн хамгийн том ширхэглэлийн хэмжээ, мм	1050
4	Бутлах хөдөлмөрийн бүтээмж, тн/цаг	70-80
5	Гарцийн амны тохиргоо хийх хязгаарлалт, мм	40-90
6	Бутлуурын цахилгаан хөдөлгүүрийн чадал, кВт	30
7	Бутлуурын гадна хэмжээс,	1700x1750x1680



Хүснэгт 5. Шигшүүрийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Тоо хэмжээ	
1	Шигшүүрийн төрөл	ЗҮК-1237	
2	Шигшүүрийн самбарын давхарын тоо	3	
3	Шигшүүрийн самбарын хэмжээ, мм	1200x3700	
4	Тэжээлийн хамгийн том ширхэглэлийн хэмжээ, мм	200	
5	Шигшүүрийн хөдөлмөрийн бүтээмж, тн/цаг	30-100	
6	Шигшүүрийн цахилгаан хөдөлгүүрийн чадал, кВт	7.5	

1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Замын хөх толгойн дайрганы ордыг ил аргаар ашиглах төслийн БОМТ-г байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9-р зүйл, Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОУАӨС-ын 2019 оны А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу БОНХСайдын 2014 оны 117 тоот “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг баримтлан боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсч болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тусгахаар хуульчлагдсаныг баримтлан боловсруулав.

Төсөл хэрэгжүүлэгч нь БОУАӨС-ын 2019 оны А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 4.1-д заасны дагуу жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор гаргаж, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтууд нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Байгаль орчны хяналтаар илэрсэн сөрөг нөлөөллийг цаг алдалгүй илрүүлж, арилгах арга хэмжээг богино хугацаанд зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан ажлуудыг хуваарийн дагуу хийж хэрэгжүүлэх
- Байгаль орчны чиглэлээр орон нутагтай хамтран ажиллах хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, өргөжүүлэх.
- Уурхайн үйл ажиллагааг орон нутгийн иргэн аж ахуй нэгж байгууллагад танилцуулах, тэдгээртэй санал бодлоо солилцож, нутгийн иргэдтэй хамтран ажиллах
- Компаниас боловсруулж, баталсан журам, зааварчилгааг өөрийн уурхайн онцлогт тохируулан хэрэгжүүлэх

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Төслийн ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны тэнцлийг хадгалах зорилгоор орчны агаар дахь хими, физикийн гаралтай түгээмэл бохирдуулагчийг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байхад оршино.

Хүснэгт 6. Сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.₮	Зардал, жилийн задаргаа сая.₮ 2026	Нийт зардал, сая.₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	5	6	7	8	9	10		
Агаарын чанар										
1.	Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас агаарт тоосжилт үүсэх	Бутлуур шигшүүрийн тоосжилтыг дарах үүднээс бороожуулагчийг тогтмол ажиллуулах	Уурхайн бутлуур, шигшүүр	л	Тухай бүр	50,000.0	2,500,000.0	2,500,000.0	Үйл ажиллагааны турш	Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
2.	Уурхайн дотоод тээврийн замаас тоосжилт үүсэх	Уурхайн дотоод тээврийн замын тогтмол маршрутыг төлөвлөж, шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх	Уурхайн дотоод зам	-	Тухай бүр	ҮАЗ	ҮАЗ	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	MNS4597:2014. Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага
		Уурхайн дотоод тээврийн зам дагуу ачаатай үед 25-30км/цаг, хоосон үед 35-40км/цагийн хурдны хязгаарлалтыг хийн, хяналтыг тавих	Уурхайн дотоод зам	Удаа	Тухай бүр	ҮАЗ	ҮАЗ	ҮАЗ	7 хоног бүр хурдны хяналтыг тавих	Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS4585:2025.
		Уурхайн дотоод шороон замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замыг засаж	Уурхайн дотоод зам	км	Тухай бүр	ҮАЗ	ҮАЗ	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	MNS 5885-2008

		сайжруулах, нягтаршуулах								
Хөрсөн бүрхэвч, газрын гадарга										
3.	Уурхайн дотоод болон гадаад тээвэрлэлт, автомашины хөдөлгөөнөөс хөрс эвдрэлд өртөх, бохирдох	Технологийн зам дагуу чиглэл, хурд заасан тэмдэг байршуулах	Төслийн талбай	ш	1	YA3			Үйл ажиллагааны турш	Газрын тухай хуулийн 56.6-р зүйл Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-р зүйл
4.	Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлж үйлдвэрийн засварын талбайд засвар хийх	Төслийн талбай	-	1	YA3	YA3	YA3	жилдээ	MNS5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
5.	Хөрс хатуу, шингэн хаягдлаар бохирдох	Хог хаягдал ангилан ялгах сав байршуулах, тогтмол их цэвэрлэгээ зохион байгуулах, Асгаралтын үед шуурхай арга хэмжээ авах, сургалт орох	Төслийн талбай	Удаа	Тухай бүр	200,000.0	200,000.0	200,000.0	жилдээ	
Усан орчин										
6.	Ордыг ашиглах явцад ил уурхайн ухааш, хаягдал чулуулгийн гадаад овоолгоос урсац үүсэх	Уурхайн хөрс, чулуулгийн овоолго, ухааш, нүүрсний овоолго зэрэг урсац үүсэж болзошгүй хэсгүүдийн гадна талаар суваг, шуудуу татах, цаг уурын мэдээ мэдээллийг тогтмол хүргэх	Төслийн талбай	Удаа	2	200,000.0	400,000.0	400,000.0	жилдээ	Усны тухай хуулийн 28, 29, 30-р зүйл
Ургамлан нөмрөг										

7.	Төслийн үйл ажиллагааны үед үүсэх тоосжилтын нөлөөгөөр тухайн хэсгийн ургамлуудын физиологийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж доройтох	Уурхайн ажилчдад төсөлд тусгасан зам харгүйгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ургамлан нөмрөг доройтуулахгүй байх талаар анхааруулга сануулга өгөх, ургамлын талаарх мэдээллийг нийт ажилтанд мэдээлэл түгээх	Төслийн ажилчид	удаа	3	20,000.0	60,000.0	60,000.0	Жил бүр 1 удаа	Байгалийн ургамлын тухай хууль Ургамал хамгааллын тухай хууль
Амьтны аймаг										
8.	Уурхайлалд өртөх талбайн хэмжээгээр биологийн олон янз байдлын амьдрах орчин доройтох, амьдрах орчноосоо дайжих	Зуд болон ган гачигтай үед орон нутагт зэрлэг ан амьтдад өвс, тэжээл, хужир, мөс тавьж өгөх зэргээр ан амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээ авах зэрэг шаардлагатай өвсийг суманд хүлээлгэн өгөх	Төслийн талбайн ойр орчимд сумын ЗДТГ	ш	1	1	ҮАЗ		Жилдээ 1 удаа	Амьтны тухай хуулийн 6-р зүйл
9.		Амьтны бүртгэл хөтлөж ERP дотоод системд оруулан цахимжуулах	Төслийн талбай	ш	бүртгэлээс	бүртгэлээс	ҮАЗ		жилдээ	
Нийт						3,160,000				

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлтийн ажлыг ил уурхайн эвдрэлд өртөх 8.7 га талбайн хүрээнд тооцох шаардлагатай боловч орд нь хэвгий уналттай, 24 жилийн хугацаанд 26 м хүртэлх гүнд олборлолт явагдах тул техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх боломжгүй бөгөөд 0.4 га газар орчны тохижилт ногоон байгууламж бий болгох шаардлагатай гэж БОННУ-нд дурдсаны дагуу 2026 онд үйлдвэрийн бүсэд 1000 ширхэг хайлаас мод тарихаар төлөвлөсөн.

Хүснэгт 7. Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээх зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, цөлөрхөг хээрийн бүс нутагт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Хайлаас мод тарих	ЦШҮ-ийн бүсэд	1000	3,500.0	3,500,000.0	жилдээ	Ерөнхий шаардлага MNS 5994:2009 Мод, сөөгний үр. Тариалалтын чанар. Техникийн шаардлага MNS 6253-2:2011 Мод, сөөгний үр тарих.
	Нийт			1000	3,500.0	3,500,000.0		

4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг холбогдох хууль дүрэм журмын дагуу боловсруулахаар төлөвлөсөн ба мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн БОННҮ-нд дурьдсан дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дагуу биологийн олон янз байдлыг хамгаалах ажлын чиглэлээр төлөвлөж байна.

Төслийн 2026 оны дүйцүүлэн хамгаалах ажлыг орон нутгийн саналын дагуу дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дунд хугацааны төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Биоллогийн олон янз байдлыг хамгаалах	Орон нутгаас санал авах	Саналын дагуу	1	6,000,000.0	6,000,000.0	жилдээ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
	Нийт					6,000,000.0		

5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайн археологийн авран хамгаалах малтлага судалгааг 2012 онд Шинжлэх ухааны академийн археологийн хүрээлэн хийж гүйцэтгэсэн бөгөөд уг судалгаагаар нийт 5 дурсгалыг малтан судалж, нөхөн сэргээж, тэмдэглэн баримтжуулалт хийсэн байна. Харин төслийн талбайн палеонтологийн нөөц баялгийн үнэлгээг 2023 онд Шинжлэх ухааны академийн палеонтологийн хүрээлэн хийж гүйцэтгэсэн бөгөөд судалгааны үед эртний амьтан ургамлын үлдвэр илрээгүй байна. Төсөл хэрэгжүүлэгч МАК цемент ХХК нь уурхайн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн дурсгал болон олдвор санамсаргүй байдлаар олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т заасны дагуу ажлаа зогсоож, энэ тухай сумын Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэж, арга хэмжээ авна.

Хүснэгт 9. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологи палеонтологийн дурсгалт эд өлгийн зүйл	Олдвор илэрвэл мэдэгдэх	Уурхайн ажилчид	1	100,000.0	100,000.0	II улиралд	МАК ХХК санамсаргүй олдворын үед ажиллах журам
		Нийт				100,000.0		

6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“МАК Цемент” ХХК нь 2025 онд ISO 45001:2018 ХАБЭА олон улсын стандартыг нэвтрүүлээд байна. Ажиллагсадын эрүүл мэнд, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд оршино.

Хүснэгт 10. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Цаг уурын урьдчилсан мэдээг хүргэж үйл ажиллагаатайгаа уялдуулах	Цаг агаарын урьдчилсан мэдээг 7 хоног тутам дотоод сүлжээгээр хүргүүлэх	Нийт ажилтан	Тухай бүр	ҮАЗ	ҮАЗ	Жилдээ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль ISO45001 ийн хүрээнд стандарт хэрэгжилтийг хангах
5	Технологийн доголдын үед гарах ослоос урьдчилан сэргийлж, ослын үед авах арга хэмжээнүүдийг төлөвлөн тусгах	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн анхан, давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах	Уурхайн ажилтан	Тухай бүр	ҮАЗ	ҮАЗ	Жилдээ	
	Аюул ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед авах арга хэмжээнүүдийн талаар мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулах	Гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллагсад мэргэжлийн байгууллагын тусламжтай сургалт зохион байгуулах	Нийт ажилтан	1	ҮАЗ	ҮАЗ	Жилдээ	Галын аюулгүй байдлын тухай хууль MNS0639:2016 . Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж, багаж болон тээврийн хэрэгслийн нэр томьёо ба тодорхойлолт
	Нийт				-	-		

7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн шингэн болон хуурай хог хаягдлын нөлөөгөөр байгаль орчин бохирдохоос урьдчилан сэргийлэх, ямар нэгэн байдлаар бохирдсон тохиолдолд тухайн сөрөг нөлөөллийг хурдан хугацаанд арилгахад оршино.

Компаний хэмжээнд мөрдөгдөж байгаа “Үйлдвэр, уурхайн хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г дагаж мөрдөх ба Уурхайн хог хаягдал ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмын дагуу ажиллана.

Машин техникүүдийн үйлчилгээг үйлдвэрийн засвар үйлчилгээний төвд хийдэг. Засвар үйлчилгээнээс гарах хаягдал ШТМ-ыг зориулалтын саванд цуглуулдаг ба Цемент шохойн үйлдвэр нь нэгдсэн журмаар хаягдал ШТМ-ыг дахин ашиглах эрх бүхий “Мон пити ойл” ХХК, Түмэн эгшиг ХХК-д нийлүүлдэг.

Хог хаягдал: Ахуйн хэрэглээний хог хаягдлыг зөвшөөрөлтэй хогийн цэгт зайлуулна. Мөн шил, лааз, хуванцар сав зэрэг дахивар хог хаягдлыг тусад нь цуглуулан хадгалж, орон нутгийн холбогдох аж ахуй нэгжид нийлүүлнэ.

Компанийн хэмжээнд мөрдөгдөж байгаа “Үйлдвэр, уурхайн хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ба уурхайн хог хаягдал ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмын дагуу ажиллана. Хог хаягдлаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөв.

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Ажилчдад хог хаягдлын талаарх сургалт орох	Төслийн талбай	Удаа	50,000.0	-	50,000.0	жилдээ	Хог хаягдлын тухай болон бусад хууль, холбогдох дүрэм журам, стандарт
		Хог хаягдлыг ангилан тээвэрлэж түр хогийн цэгт тогтмол хүргэх	Төслийн талбай	Удаа	ҮАЗ	-	ҮАЗ	Жилдээ	
4	Аюултай	Тэсэлгээнд ашигласан сав баглаа боодлыг тухайн тэсэлгээний компани хариуцан устгал хийх, хяналт тавьж ажиллах	Төслийн талбай	Удаа	ҮАЗ	-	ҮАЗ	Жилдээ	
Нийт							50,000.00		

8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт шинжилгээний хөтөлбөрийг БОННУ-нд зөвлөмж болгосны дагуу тодорхойлсон хяналтын цэгүүд дээр, хуваарийн дагуу явуулж уурхайн үйл ажиллагаанаас үүсэн гарах нөлөөллийг хянах, хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах явдал юм. Хяналт шинжилгээнүүдийг мэргэжлийн эрх бүхий байгууллага буюу Дорноговь аймгийн УЦУОШГ-аар агаар, хөрс, усны шинжилгээг хийлгэнэ. Мөн дотооддоо тоосжилт PM(10), PM(2.5) –ыг DUST TRAK 8530 багажаар, ажлын байран дахь дуу чимээг TESTO815 гэсэн багажуудаар хэмжилт, мониторингийг, Раменскийн тор ашиглан ургамлын мониторингийг тус тус хийнэ.

Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Зардал (1 жил),₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1		2	3	4	5	7
Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр						
1	Дуу чимээ	- Ил уурхай - Зам дагуу 2	3	-	200,000	MNS 4585:2025.
2	Агаарын чанар Орчны тоосжилт (PM _{2.5} , PM ₁₀ TSP, CO, NO ₂ , SO ₂)	- Уурхайн зам 1 - Ил уурхай 1 - Зогсоол 1	3	7 хоногт 1 удаа	100,000	MNS 4585:2025 MNS ISO 4227-2002
3	Ургамлан нөмрөг Ургамлын зүйлийн бүрдэл Ургамлан нөмрөгийн бүрхэц	Орчны бохирдолд өртөж болзошгүй цэг болон алслагдсан цэгүүд	3	Жилд 1 удаа	100,000	Батлагдсан арга зүйн дагуу
4	Амьтдын аймаг Амьтдын нүүдэл шилжилтийн мониторинг Амьтдын тоо толгой	Төслийн талбайд	3	Жилд 2 удаа	60,000	
Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр						
1	Агаарын чанар Орчны тоосжилт (PM _{2.5} , PM ₁₀ TSP, CO, NO ₂ , SO ₂)	Дотоод хяналт шинжилгээний цэгүүдэд	2	Жилд 2 удаа	1 дээж 100,000*2 Жилд 400,000	MNS4585:2025. MNS ISO4227-2002
2	Хөрсний хими болон физик Хүнд металл	Дотоод хяналт шинжилгээний цэгүүдэд	2	Жилд 2 удаа	1 дээж 35,000*2 Жилд 140,000	MNS 2305:1994 MNS 5850:2019

3	Усан орчин Ерөнхий хими, физикийн шинжилгээ Хүнд металлын шинжилгээ	Замын хөх толгойн лицензийн талбайн ойролцоох нуураас	1	Жилд 2 удаа	1 дээж 30,000*2 Жилд 60,000	MNS 0900:2018 MNS6148:2010 MNS ISO5667-11:2000.
Нийт		1,060,000 төгрөг				

9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Уурхайн үйл ажиллагаа явуулах хугацаанд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалт, сурталчилгаа, мөрдөгдөх журам, төлөвлөгөөг цаг алдалгүй хийх тухайн ажлыг зөв зүйтэй зохион байгуулахад оршино.

Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөв.

Түгээсэт 18: 6 сарын 15-н өдөр болсон бэлтгэл ажлын үр дүнд төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025				
			Сар	Сар	сар		
1	Байгаль орчны сургалтад нийт ажилтнуудыг хамруулах, оролцоог нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах	Үйл ажиллагааны зардал	4	7	9	ХЭМАБ, БОТХХ	-
2	Уурхайн газрын гэрээг хийж, төлбөр төлөх	Үйл ажиллагааны зардлаас	3	4	5	Газрын асуудал хариуцсан ажилтан	-
4	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр орон нутаг болон иргэдтэй хамтран ажиллах санал санаачлагыг өөрийн нөхцөл боломжийн хүрээнд хэрэгжүүлэх	ҮАЗ	1	5	10	Байгаль орчны мэргэжилтэн	-
5	Нөлөөллийн бүсийн малчдад өвс тараах	200,000.0	Тухай бүрт	Тухай бүрт	Тухай бүрт	Уурхайн удирдлага, Байгаль орчны мэргэжилтэн	-
6	Эрүүл мэндийн үзлэгт нөлөөллийн бүсийн малчдыг хамруулах	100,00.0	-	-	11	Уурхайн удирдлага, Байгаль орчны мэргэжилтэн	-
	Нийт	300,000.0					

10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа орон нутгийн иргэд болон төрийн байгууллагыг үнэн зөв бодит мэдээллээр хангахад оршино.

Хүснэгт 14. Олон нийтэд тайлагнах хуваарь

№	БОХТ-ийн биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	Даланжаргалан сумын иргэд, цомог багийн хуралд танилцуулах	Биечлэн	Тухайн жилийн БОМТ-ний тайлангийн хэрэгжилт	III, IV-р улиралд	100,000.0	Байгаль орчны мэргэжилтэн	МАК Цемент ХХК
	Нийт				100,000.0		

11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО

2026 онд Байгаль орчныг хамгаалах ажилд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийтдээ **14,270,000** төгрөг зарцуулна.

Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний урьдчилсан зардал

Дд	Хийгдэх ажлууд	Зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,160,000
2	Нөхөн сэргээлтийн ажил	3,500,000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	6,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговрын зардал	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах зардал	100,000
6	Осол эрдэслийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд зарцуулах зардал	ҮАЗ
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд зарцуулах зардал	50,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,060,000
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	300,000
10	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэхэд гарах зардал	100,000
Нийт		14,270,000